



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

20 20 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 4/156

Алтай хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/118 дугаартай “Алтай” чуулгын хуучин барилгыг “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үнэлгээний хорооны захирамжийн 1 дүгээр хэсэгт “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн” гэснийг “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -“Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн” мөн “Үнэлгээний хорооны гишүүн: Д.Анхбаатар - Боловсрол, соёл, урлагийн газрын төсвийн мэргэжилтэн” гэснийг “Т.Болд -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн” болгон тус тус өөрчилсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Алтайбаатар)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

